

Цуврал № 3:

Цөмийн хаягдлын бизнест хэн хэн оролцож байна вэ буюу сэтгэл амарч тайвшрах цаг ирсэн үү?



Өмнөх үг

Миний бичсэн “Цөмийн хаягдлын бизнест хэн хэн оролцож байна вэ?” гэсэн 1,2-р цувралыг уншин эргэцүүлж, сэтгэгдлээ хуваалцаж, урам хайрласан уншигчиддаа баярлалаа. Эдгээр болон бусад нийтлэлүүдийг www.golomt.org дээрээс уншиж, бас татаж авах боломжтой байгаа.

Бузар үйлдлийг нь баримтаар илчилсэнд хорсогчид миний тухай элдэв цуу тарааж, Н. Энхбаярын гар хөл хэмээн гүтгэж, олон нийтийн итгэл үнэмшлээр тоглохоор улайн цайм шамдаж байгаагаас үзвэл миний тавьсан үгэн “сум” онилсон байнууддаа мэргэн тусчээ.

Ингээд цувралын сүүлчийн хэсгийг толилуулья. Материалыг Япон хэлнээс орчуулахад гүн туслалцаа үзүүлсэн Санги Байгаль, Мээдээ нартаа, мөн цөмийн бизнесийн аалзны тор сүлжээг зурж тусалсан Л. Мөнхтөрдөө баярлалаа.

Өнгөрсөн 9 дүгээр сард Монгол улсын ерөнхийлөгч НҮБ-ын индэр дээрээс гадны цөмийн хаягдал булшлахгүй гэж ёслол төгөлдөрөөр мэдэгдэж, энэ асуудлаар бүрхэгдүүхэн зарлиг гаргаснаар айдас түгшүүр бүрэн ариллаа гэж сэтгэл амран тайвширч боломгүй гэдгийг та бүхэнд сануулахыг хүссэн юм шүү.

Цуврал № 2-г бичиж байхад А. Ундрааг ажлаас нь чөлөөлсөн. Харин энэ нийтлэлийг дуусч байх үед Р. Бадамдамдинг албан үүргээс нь чөлөөлсөн тухай мэдээ гарлаа. “Унасан хүнийг өшиглөх муухай” ч учрыг та бүхэнд бүрэн тайлбарлах үүднээс цувралыг олны хүртээл болгохоор шийдэв.

Олон аалзыг нэг саванд хийвэл хүч багатайгаасаа эхлэн бие биеэ барьдаг гэнэ лээ...

Хүндэтгэсэн,

Амарлин (amarlin06@gmail.com)

Цуврал № 3: <http://golomt.org/2011/10/25/business3/>

Цуврал № 2: <http://golomt.org/2011/10/11/business2/>

Цуврал № 1: <http://golomt.org/2011/09/06/who/>

Нэг. МонАтом ХХК-ний түүхээс

“МонАтом” ХХК гэдэг төрийн өмчийн компанийн талаар хүмүүс төдийлэн сайн мэддэггүй. Албан ёсны эх сурвалжаас үзвэл, 2009 оны 2 сарын 11-нд гарсан Ерөнхий сайд С. Баяр, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга Б. Долгор нарын гарын үсэгтэй Засгийн Газрын 45-р тогтоолоор байгуулагдсан юм байна (1). Захирлаар нь Р. Бадамдамдин, дэд захирлаар нь Г. Цогтсайхан ажилладаг гэдгээс цааш мэдээлэл элбэг бус.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ	
ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИ БАЙГУУЛАХ ТУХАЙ	
2009 оны 2 дугаар сарын 11-ний өдөр	Улаанбаатар хот
Дугаар 45	
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.5, Компанийн тухай хуулийн 1.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:	
1. Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх үүрэг бүхий “Мон-Атом” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсугай.	
2. “Мон-Атом” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн санг бүрдүүлэхэд шаардлагатай 100.0 (нэг зуун) сая төгрөгийг Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган шийдвэрлэхийг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.	
3. Компанийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж, үйл ажиллагааг нь зохих журмын дагуу эхлүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар), Цөмийн энергийн газрын дарга С.Энхбатад даалгасугай.	
Монгол Улсын Ерөнхий сайд	С.БАЯР
Монгол Улсын сайд,	
Засгийн газрын Хэрэг	
эрхлэх газрын дарга	Б.ДОЛГОР

Бүр нарийн сурвалжилвал “МонАтом” ХХК-ийг байгуулахад Төрийн Өмчийн Хорооны (ТӨХ) дарга Д. Сугар нэлээдгүй үүрэг гүйцэтгэсэн байна. Тухайлбал, 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн ТӨХ-ны 49-р тоот тогтоолоор “Мон-Атом” ХХК-ийн дүрмийг баталж (2), ТУЗ-ийн даргаар Цөмийн Энергийн Газрын (ЦЭГ) дарга С. Энхбат,

гишүүдээр ЭБЭХ-ний Төрийн нарийн бичгийн дарга Д.Хүрэлбаатар, Сангийн Яамны ТБГ-ын дарга Б. Батжаргал, ЦЭГ-ын дэд дарга Ц. Дамдинсүрэн, ТӨХ-ны даргын зөвлөх Д. Байлхүү нарыг томилсон байна (3). Шинэхэн ТУЗ нь тэр өдөртөө шалавлан хуралдаж 02 тоот тогтоолоороо “МонАтом” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Р. Бадамдамдинг сонгожээ (2,4).

Хоёр. Танилц—“МонАтом Жапан”

Ийнхүү байгуулагдаад 2 жил гаруй болсон ч “МонАтом” ХХК-иас Монголдоо хийсэн бүтээсэн зүйл үзэгдэж мэдэгдэх нь бага ажээ. Харин гадаад орнуудад, тэр тусмаа Японд бол нэлээдгүй идэвхтэй аж. Тухайлбал, “МонАтом” ХХК-ийн охин компани Японд байдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй. Тиймээс “МонАтом Жапан” компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл авахаар япон хэл дээрх <http://www.monatom-j.jp> цахим сайттай нь танилцсан юм (5).

MONATOM JAPAN

HOME	モンゴル政府からのメッセージ	会社概要	Our Business stage	Our Mission	ウラン・原子力開発 レアメタル等その他資源 輸送・インフラ等	お問い合わせ
------	----------------	------	--------------------	-------------	--------------------------------------	--------

『資源から紡ぐ世界への架け橋』～子供に誇れる豊かな未来を～
モンアトム・ジャパンは地下資源開発を起点に、日本・モンゴル両国の経済発展と地球環境保全に貢献します。

■ What' new
2010.02.17 ニュースをごらんください。
最近の新聞情報より **NEW**

Эх сурвалж: <http://www.monatom-j.jp>

Нүүр хуудасны дараагаар Монгол улсын тухай товч танилцуулга, мөн Монгол улсын Засгийн газар, Цөмийн Энергийн Газрын өмнөөс мэндчилгээ дэвшүүлсэн С. Энхбатын мэндчилгээ байна.

MONATOM JAPAN

HOME Монгол政府からのメッセージ 会社概要 Our Business stage Our Mission ウラン・原子力開発、レアメタル等その他資源、輸送インフラ等 お問い合わせ

Message from Mongol

経済は2000年以降、鉱業、畜産業に支えられ、順調に推移(最近の成長率は年率約10%)し、鉱物資源の輸出は輸出総額の8割を超える重要産業となっています。政府は2006年に鉱業法の改正を行い、外資導入を促進する一方で技術導入を図り、自国内での産業基盤の確立を目指しています。

日蒙協調によるエネルギー開発、環境保全の牽引役としての役割に期待しています。

日本国のみならず、そして関係者のみならずには、このたびはMONATOM JAPANの会社設立おめでとうございます。わが国と日本国とは永年にわたり友好関係を築いてきた歴史がございます。ここ数年はその関係強化に拍車がかかっております。このたびのMONATOM JAPAN設立はわが国と日本国が資源開発を通じて、エネルギー問題や環境問題で、協調して世界規模に貢献できる絶好の機会と認識しております。

モンゴルは鉱物資源の宝庫ですが、その大部分が未だ開発途上であり、そのための優れた技術や設備、人材・資金を友好関係にある日本のみならず方に支援して頂く必要があります。特にウラン開発、精錬技術、核エネルギー開発などの分野への出資、また技術者の育成、共同研究開発、新技術の導入に関して、大きな期待を寄せている国は日本です。

日本国とわが国には、将来のビジネスにおいて、互いにその要求に応えられるチャンスが揃っています。そのための商法の見直しや規制緩和など法整備の問題も含め、現在国を挙げて取り組んでおります。

MONATOM JAPANが、これからのモンゴル国と日本国のビジネス発展のための牽引役として活躍されることを期待しております。

最後になりましたが、日本の皆様とMONATOM JAPANの関係者に事業の発展と成功をお祈りいたします。

モンゴル政府 核エネルギー局長 **СЭНХБАТ**
(エンクバト氏)

モンゴル政府 核エネルギー局長 **СЭНХБАТ**

С. Энхбат “МонАтом Жапан” компанийг байгуулсанд баяр хүргээд “Монгол улс ураны асар их нөөцтэй боловч түүнийгээ олборлон ашиглаж эхлээгүй, өндөр төвшний техник технологи нэвтрүүлэх, боловсон хүчнийг сургах, хөрөнгө оруулалт хийх зэрэгт

Япон улсын дэмжлэг туслалцаа шаардлагатай байна. Бид уран олборлох, баяжуулах технологи, цөмийн эрчим хүчний салбарыг хөгжүүлэхдээ Япон улсад маш их найдлага тавьж байна. **Хариуд нь Монголчууд худалдааныхаа хуулийг засварлаж, гаалийн татварыг хөнгөлөх зэрэг эрх зүйн таатай орчин бүрдүүлэхээр ажиллаж байна**” гэжээ.

MONATOM JAPAN						
HOME	モンゴル政府からのメッセージ	会社概要	Our Business stage	Our Mission	ウラン・原子力開発 レアメタル等その他資源 輸送・インフラ等	お問い合わせ

会社概要



会社名 : **MONATOM JAPAN**

本部所在地 : **541-0047 大阪市中央区内淡路町2-4-7**

東京事務所 : **151-0073 東京都渋谷区笹塚3-52-10**

電話 : **06-6942-6300**

メールアドレス : **maj@adonet.co.jp**

最高経営責任者 (CEO) : **植村宏一郎**

事業内容 : **モンゴル資源開発総合コンサルティング**

関連会社 : **1) MONATOM,LLC. (モンゴル国・核エネルギー局直轄国営会社)
2) MONTASKTEX (モンゴル)**

Гуравдахь хуудсанд “МонАтом Жапан” компаний хаяг, захирал, харилцах утасны дугаар зэргийг өгчээ. Нэг сонирхолтой нь “Хариуцсан компани” гэдэг хэсэгт “МонАтом” ХХК -аас гадна “МонТаскТекс” (“MonTaskTex”) гэдэг үл мэдэгдэх компани бичигдсэн байна.

Our Business stage

代表者ご挨拶



モンゴル国営 モンアトム
"MONATOM" LLC.
CEO (最高経営責任者)
BADAMDANDIN Regchaа
(バダムダムティン氏)

MONATOM JAPANの設立に際し、みなさまにご挨拶申し上げます。
ご承知の通り、モンゴル国は鉱物資源の宝庫として世界的に注目されています。とりわけこれからのクリーンエネルギーとして開発が期待されているのが「ウラン」です。現在、モンゴル国にて正式に確定されている埋蔵量として6万3,000トンと世界15位、今後も埋蔵量増加の可能性が高い(IAEAの2008年の調査では推定埋蔵量は140万トンと書かれている)ものとして期待を寄せています。

そんな中、モンゴル国議会はウラン開発に関するさまざまな国策を検討してまいりました。そして原子力のための機関を設立し、将来のウラニウムプロジェクトに参加するために、2009年3月に国営企業"MONATOM" LLCを設立致しました。同時に各国との連携強化を図るべく、官民一体で協議を重ねてまいりましたが、この度、日本国内において最良のパートナーとめぐり合い、日本法人を設立する運びとなり、私たちは大変喜んでおります。

モンゴルのビジネス環境は、日本に比べまだまだ小規模で黎明期ともいえます。しかし、資源という未曾有の可能性を秘めており、それらをいかに有効に引き出し、結実させるかがみなさまと私たちの役割と責任となっております。そしてこれから日本のみなさまとしっかりと連携しながら、相互発展に向け努力する所存です。

みなさまに仕事の成功をお祈りいたします。なにとぞよろしくお願い申し上げます。

Badamdandin Regchaа

Удаахь “Our Business Stage” хуудсанд төрийн өмчийн “МонАтом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Рагчаагийн Бадамдамдингийн Японы ард түмэнд хандсан мэндчилгээ байсныг сийрүүлвэл: “Монгол улс, уул уурхайн нөөц баялгийн хэмжээгээр дэлхийн анхаарлын төвд орсон, нэн ялангуяа, **байгальд ээлтэй, цэвэр эрчим хүчний эх үүсвэр болох ураны** олборлолт ихээхэн итгэл төрүүлж байна. Монгол улс ураны нөөцөөрөө дэлхийд 15-д ордог. Албан ёсоор 63 мянган тонн ураны нөөцтэй, харин Олон Улсын Атомын Энергийн Агентлагаас 2008 онд явуулсан судалгаагаар 1,4 сая тонн нөөцтэй гэж тогтоогдсон. Монголын Засгийн газраас ураны олборлолтын талаар төрийн бодлого явуулж байна. Ураны асуудлаар төсөл хэрэгжүүлэхийн тулд 2009 оны 3 сард төрийн өмчийн “МонАтом” ХХК-ийг байгуулсан. Бид Японы компанитай холбогдож, хамтран ажиллахаар тохиролцож, улмаар энэхүү Япон компанийг үүсгэн байгуулсан явдалд туйлын их баяртай

байна. Монголын бизнесийн орчин Японыхтой харьцуулахад харьцангуй жижиг ч ирээдүй нь гэрэлтэй байна. **Монгол улс ашигт малтмалын арвин их нөөцтэй ба түүнийг олборлож, ашиглах нь та бидний хариуцлага**” гэжээ.



Энэ хуудсанд өлзий дэмбэрэлтэй өдөр болох 2009 оны 09 сарын 09-нд “МонАтом” ХХК-ийн компанийн Япон дахь салбарыг байгуулж, захирлаар нь Уемура Коичиро гэгчийг томилсон бичгийг Монгол, Япон хэл дээр үйлдсэнээ байрлуулжээ.



モンアトム・ジャパン
MONATOM JAPAN
CEO(最高経営責任者)
植村 宏一郎

このたびの日本法人開設にあたり、モンゴル国の政府関係者並びに日本国政府関係者や各種法人・企業のみなさまに多大なご協力とご支援賜りました事、誠に厚く御礼申し上げます。

みなさまご承知の通り、モンゴル国は、加熱する世界的な資源・エネルギー開発の潮流の中、その将来性で最も注目される国の一つであり、日本にとって、ビジネスレベルでもこれからますます関係を深めるべき相手先でもあります。

今回のMONATOM JAPANの設立を契機に、私共は、同国の単なる資源・エネルギー開発にとどまらず、同国が持つ資源・資産を背景に、日本企業の持つ技術力や生産力、ネットワーク力を融合させ、共に繁栄できるビジネス基盤づくりのお手伝いをしたいと考えております。

同国と協働して、地球規模での効率的な資源エネルギー開発と環境問題に取り組んでまいりたい所存です。どうぞこれからの私共の活動にご期待下さい。

植村 宏一郎


Дор нь Үемуро Коичиро мэндчилгээ дэвшүүлж, шинээр байгуулагдсан “МонАтом Жапан” компани нь хоёр орны хөгжил дэвшилд хувь нэмэр оруулахын тулд 7 чиглэлээр үйл ажиллагаа явуулна гэжээ. Үүнд:

1. Монголын ашигт малтмалын, нэн ялангуяа ураны тухай судалгаа шинжилгээний мэдээллээр хангах (хайгуул хийх, олборлох төлөвлөгөө, нөөцийн хэмжээ, чанар, хууль эрх зүйн асуудал, газар зүйн байршлын талаарх мэдээлэл)
2. Цөмийн эрчим хүчний салбарын технологийн дэмжлэг үзүүлэх (уран баяжуулах технологи, **цөмийн түлшний циклийн технологи**, цөмийн реактор, АЦС барихад шаардагдах техник технологи)
3. Ашигт малтмалын орд газруудаар очиж танилцуулах, ордуудын тухай танилцуулах сургалт семинар зохион байгуулах
4. Японы компанитай хамтран ашигт малтмалын хайгуул хийх
5. Монголын ашигт малтмалын эрэл хайгуулын тухай мэдээллээр хангах

6. Японд буй харилцагч компаниудтай гэрээ хэлэлцээр байгуулах
7. Бусад гэрээ хэлэлцээр, тухайлбал, худалдааны хэлэлцээр хийх орсон байна.


Дараах хуудсанд “МонАтом Жапан” компаний хэтийн зорилго нь Монголын “МонАтом” компанитай хамтран уран болон бусад ашигт малтмалыг олборлоход Японы хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, бизнесийн таатай орчныг бий болгож, хамтын ажиллагааг дэмжих гээд компаний үйл ажиллагааны чиглэлүүд нь:

1. Уран ба цөмийн эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, дэлхийн зах зээлд гарах боломжийг бүрдүүлэх
2. Газрын ховор металл болон бусад ашигт малтмалыг олборлохыг дэмжих
3. Зам тээвэр дэд бүтцийг хөгжүүлэх, үүнд дотоодын зам тээврийн дэд бүтцийг сайжруулах, Монгол улсаас гадагш Японы тэнгис хүртэл тээвэрлэх дэд бүтцийг бий болгох ажээ.



Доор нь Монголын ашигт малтмалын газрын зургийг тавьсан бөгөөд улаанаар ураны ордуудын байршлыг үзүүлжээ.

Хажууханд нь “МонАтом Жапан” компаний бизнесийн ерөнхий тойм гэж бичээд АЦС байгуулахтай холбоотой үйл ажиллагаа, үүнд , машин техник нийлүүлэх, **агуулах байгууламж барих, цөмийн ашигласан түлшийг дахин боловсруулах** гэж заажээ.



Дараагийн хуудсанд Монгол улсын ураны орд газрууд, тэдгээрийн тогтоогдсон ба бэлтгэл нөөцийн хэмжээг хүснэгтээр өгөхдөө нэг чухал схем үзүүлжээ. Та бүхэнд ойлгомжтой болгох үүднээс түүнийг Монголоор толилуулъя. Цөмийн түлшний циклийн үе шат бүрт ялгардаг хорт хаягдлын хор хөнөөлийг тодорхой болгох үүднээс тусгай тэмдэглэл нэмснийг анзаарна уу.

Ямар ч байсан энэ хүснэгтэнд Монголын ураныг Японы технологиор олборлож, боловсруулж, ашиглаад, баяжуулах явцад гарсан ядуурсан ураны хаягдлыг нь Монголд буцааж өгөөд харин өндөр төвшний цацраг идэвхт хаягдал буюу цөмийн ашигласан түлшний хаягдлыг нь түр болон бүр хадгалах (булшлах) тухай

тодорхой үзүүлжээ. Мэдээж, Монголын нутаг дээр булшлах болж таарна.



Дараачийн хэсэгт Монголын дэд бүтцийг хөгжүүлэх тухай бичихдээ Монголын Дорнод хавиас Японы тэнгис хүртэл төмөр зам тавих төлөвлөгөөг бүдүүвчлэн үзүүлсэн байна.



Энд нэг сонирхолтой баримт хавсаргасан нь нэгэн Монгол хүн өөр нэг Монголдоо хандаж англиар бичсэн албан бичиг юм. Уншигчдад ойлгомжтой болгох үүднээс орчуулгыг дор тавив. ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг болох Төмөр Замын хэрэг эрхлэх газрын дарга Д. Ганболдоос УИХ-ын эрхэм гишүүн, Зүүн бүсийг хөгжүүлэх сангийн ерөнхийлөгч М. Зоригт гэгчид хандсан хамтран ажиллах тухай захидалд ингэж бичжээ.

2008 оны 3 сарын 20

Эрхэмсэг ноён М. Зоригт танаа,

Дорнод аймгийн Чойбалсан хотоос Монгол, Хятадын хил хүртэл 473 км үргэлжлэх “Зүүн бүсийн төв зам” гэдэг нэртэй төслийг баримтыг ирүүлсэнд гүнээ талархая. Энэ төслийг хэрэгжүүлэх нь Монголын зүүн бүсийн эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх төдийгүй гурван орны хөгжил дэвшилд чухал хувь нэмэртэй нь тодорхой юм.

Чойбалсан-Тамсагбулаг-Халхын Гол-Аршаантыг холбосон төмөр зам тавих нь Монголын төмөр замын сүлжээний цаашдын хөгжлийн зорилготой нийцэж байгаа тул бид таны саналыг баяртайгаар хүлээн авч, дээрх төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахад бэлэн байна.

Хүндэтгэсэн,
Д. Ганболд



GOVERNMENT IMPLEMENTATION AGENCY
RAILWAY AUTHORITY OF MONGOLIA

Date: 2008.03.20

Ref: 0-1/119

For the kind attention of Mr. M.Zorig,
Head of the Three side Committee " East Great Thoroughfare",
President of East Mongolia Development Foundation,
Member of Parliament of Mongolia

LETTER OF COLLABORATION

Dear Mr. M.ZORIGT,

Herewith we thankfully acknowledge the receipt of your Application for the Railway Construction of East Great Thoroughfare, particularly to construct 473 km railway line from Choibalsan city, Dornod aimag to the border of Mongolia and China. We understand that implementation of this project will contribute a lot to the overall development of Mongolian eastern region economy as well as to the economic development of three countries.

Bearing in mind that construction of the railway line between Choibalsan-Tamsagbulag-Khaikhyn Gol-Arshaant is the part of further development of Mongolian railway network system, we welcome your proposed project and are willing to assist and collaborate with you in the implementation process of above project.

Sincerely yours,


D.GANBOLD
Chairman

210628 Ulaanbaatar,
Sukhbaatar dsureg,
Chingisiin urgan chuluu-11

Phone: 976-21-944849
Fax: 976-21-942864
E-mail: mra@railcom.mn.agency

Гурав. Энэ бүхэн юу өгүүлнэ вэ?

“МонАтом Жапан” компаний цахим хуудсанд өгөгдсөн мэдээллийг эргэцүүлж үзвэл хэд хэдэн зүйл тодорхой болж байна:

1) Монгол улсын стратегийн чухал ач холбогдолтой ашигт малтмал болох уран болон газрын үнэт металлыг гадныханд найр тавин өгч, яаралтай үрэн таран хийхээр асар ихээр шамдаж, ил болон далдуур тохиролцож буй дүр зураг ажиглагдаж байна.

Монголчууд уран олборлох, баяжуулах технологи, цөмийн эрчим хүчний салбарыг хөгжүүлэхдээ Япончуудад асар их найдлага тавьж байгаа нь анзаарагдав. Монгол улс судалгаа, эрэл хайгуул хийх, олборлох, боловсруулах, боловсон хүчин бэлтгэх, дэд бүтцээ байгуулах зэрэг ерөнхийдөө БҮХ АСУУДЛААР гадны хөрөнгө оруулалт, техникийн зөвлөгөө, машин техник, технологийн туслалцаа хүсч байна. **Хариуд нь Монгол улс хамгийн таатай хууль эрх зүйн, татварын, гаалийн орчныг бүрдүүлнэ гэж амлажээ.**

Ийм нөхцөлд хийгдэх хамтын ажиллагаа нь тэнцвэртэй, худалдаа наймаа нь харилцан ашигтай байж чадна гэдэгт гүнээ эргэлзэж байна. Зүйрлэвэл, амтат чихэр, хүзүүний зүүлт, эрээн даавуу зэрэг аахар шаахар зүйлээр газар нутгаа наймаалцсан Америкийн уугуул иргэд болох Индианчуудын хувь заяа санаанд орж байх юм.

2) Монголын уран, газрын ховор металл, бусад баялгийг өөрсдийн зорилгод овжноор ашиглах улс төрчдийн бүлэглэл, сүлжээнүүд хамтран ажиллах болжээ.

Тухайлбал, дээрх захидлаас үзэхэд гадагш чиглэсэн Дорнодын төмөр замын санаачлагыг анх 2008 онд УИХ-ын гишүүн байсан, одоо ИЗ-НН-д дээгүүр алба хашдаг М. Зоригт гэгч Д. Ганболдод тавьж байсан ажээ. Харин судлаач Д. Ганхуяг гуайн бичсэнээс үзвэл “арав гаруй жилийн өмнө “халзан” Д.Ганболд





гадаадынхантай нийлж газрын ховор “юм” хайж байна гэх мэдээлэл анх сонсож билээ” хэмээн бичсэн байна (6). Газрын ховор металл гэдэг зүйл нь та бидний өдөр тутмын хэрэглээ болж буй зөөврийн компьютер, гар утаснаас авахуулаад орчин

үеийн шинэ технологи болох iPod, iPhone, iPad зэргийг үйлдвэрлэхэд онц шаардлагатай эд аж.

Манай гаригийн ховор металлын томоохон экспортлогч нь Хятад улс юм байна. Сүүлийн жилүүдэд Хятад, Японы харилцаанд улам хүйтрэх хандлага нэмэгдэж буйн улмаас Хятадуудаас дэндүү их



хараат байдалд орсон Япончууд газрын ховор металлыг олж авах бусад гарцыг улам идэвхтэй эрэлхийлэх болжээ. Ингэхээр Дорнодыг Хятадтай, цаашилбал, Японы Тэнгис руу хүрэх гарцыг бий болгох М Зоригтын санаачлага гадныхантай

нийлээд Монголын газрын ховор металлыг эрж явсан Д. Ганболдын сонирхолд ч бас гүнээ нийцэж байсан нь ойлгомжтой .

Энэ дашрамд дурьдахад Мардайгаас Чингисийн далан хүртэлх 131 км урттай Оросуудын ашиглаж байсан төмөр замыг үрэн таран хийж, мөнгийг нь хармаалсан гол эзэн нь ТӨХ-ны Д. Сугар гэж хэвлэлээр бичдэг (7,8,9). Одоо тэгвэл Д.Сугарын томилсон Р. Бадамдамдин дотоодын дэд бүтцийг дахин байгуулж, гадагш чиглэсэн төмөр зам тавихаар Япончуудтай тохиролцож байгаа болж таарч байна. Төмөр зам барьсан нөхцөлд уранаа зөөж гаргаад буцаагаад хаягдлыг нь тээвэрлэх боломж нээгдэнэ. Мөн газрын үнэт металл гаргах, Д. Ганболд, М. Зоригт нартай хамтрах боломжууд ч өргөн аж.

3. Японы талаас цөмийн эрчим хүчний салбарын технологийн дэмжлэг буюу уран баяжуулах технологи, цөмийн түлшний циклийн технологи зэргийг нэвтрүүлж, агуулах байр барьж, цөмийн түлшний хаягдлыг дахин боловсруулахад тусална гэжээ.

Үүнд, нэгдүгээрт, уран олборлох, боловсруулах үе шат бүрт хорт хаягдал гарна, хоёрдугаарт, цөмийн түлшийг дахин боловсруулах аюулгүй, баталгаатай технологи одоо хүртэл байхгүй гэдгийг санах хэрэгтэй юм. Энэ тухай баримтад түшиглэн тайлбарлая:

Япон улсад дахин боловсруулах ганц үйлдвэр нь Ибараки мужийн Токайд байдаг хүчин чадал багатай Токаймура үйлдвэр. Тус үйлдэр дээр 1999 онд осол гарсны улмаас 2 хүн амь насаа алдаж, дор хаяж 667 хүн цацраг идэвхтэй туяанд өртжээ (10). Харин цөмийн салбарыг дэмжигч байгууллага болох Дэлхийн Цөмийн Энергийн Ассоциацийн цахим сайтад 2 хүн амь алдаж, 167 хүн цацраг идэвхид хордсон гэж бичсэн байна (11).

1993 оноос хойш Аомори мужийн Рокашод шинэ үйлдвэр барьж буй ч тус үйлдвэрийн туршилтууд амжилтгүй байгаа тул ашиглалтанд орох хугацаа нь анх төлөвлөснөөсөө даруй 15 жилээр хоцорч байгаа ажээ (12, 13). Тус байгууламжийг байгуулахад өнөөг хүртэл 20 тэрбум долларын хөрөнгө зарцуулсан нь анхны тооцооноос даруй 3 дахин өндөр байна (14).

Нарийн нямбай, хөдөлмөрийн аюулгүй байдал, цагийг яг таг баримталдаг Япончууд алдаж эндэж явна. Монголчууд тэндээс дээр байж чадах уу? Дахин боловсруулах үйлдвэр барих хөрөнгө бидэнд байгаа бил үү?

Дөрөв. Цөмийн аюул бүрэн сарнисан уу?

Эрх мэдэлтнүүд мэдэн будилж, гадны цөмийн хаягдал Монголд булшлахгүй гэж зарлаж байвч цөмийн түлшний иж бүрэн үйлчилгээ гэгчийг үзүүлэх аргаар Монгол улсад гадаад орнуудын ашигласан

цөмийн түлшний хаягдлыг булшлах төлөвлөгөө үргэлжлэн хэрэгжсээр байна.

Үүний нэг баталгаа нь НҮБ-д суугаа байнгын төлөөлөгч О. Энхцэцэгийн 2011 оны 10 сарын 7-нд НҮБ-ын хурал дээрх илтгэл юм. Тэрбээр: “Зарим хэвлэлд Монгол улс өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын цөмийн түлшний хаягдлыг хадгалах байгууламж байгуулж, бусад орнуудын цөмийн хаягдлыг импортлон оруулна гэсэн мэдээ гарч байсан. Энэ бол үндэслэлгүй зүйл. Гадны цөмийн хаягдлыг импортлон оруулж ирэх нь Монгол улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн хэрэг болно. Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулинд “Монгол улсын газар нутаг дээр ... цөмийн хаягдал хаяхыг” хориглосон байдаг. Тэгээд ч **Монгол улс гадны гаралтай цөмийн хаягдлыг нутагтаа оруулж ирэхээр хуулиа өөрчлөх бодолгүй байгаа**” гэжээ (15).

MONGOLIA
PERMANENT MISSION TO THE UNITED NATIONS
6 East 77th Street, New York, N.Y. 10075
Tel: (212) 861-9460 Fax: (212) 861-9464
e-mail: mongolia@un.int

Please check against delivery

STATEMENT BY
H.E. AMBASSADOR ENKHTSETSEG OCHIR,
PERMANENT REPRESENTATIVE OF MONGOLIA TO THE UNITED NATIONS

AT THE GENERAL DEBATE OF THE FIRST COMMITTEE OF
THE 66TH SESSION OF THE UN GENERAL ASSEMBLY

2011 оны 10 сарын 7-ны
НҮБ-ын Ерөнхий
Ассемблейн 66-р
хуралдаан дээр НҮБ-д
суугаа элчин сайд О.
Энхцэцэгийн хэлсэн
үгнээс....

There have been reports in some media that Mongolia has been in talks to host an international spent fuel storage facility on its territory and import nuclear waste from other countries. Those claims are groundless. Importing foreign nuclear waste would be in gross violation of Mongolia's domestic laws and regulations. The Law on Mongolia's nuclear-weapon-free status expressly prohibits "dumping or disposing of ... nuclear waste on Mongolia's territory". Furthermore, Mongolia has no intention to change its legislation to bring foreign-origin nuclear waste into its territory.

O. Enkhsetseg
New York

http://www.reachingcriticalwill.org/political/1com/1com11/statements/7Oct_Mongolia.pdf

О. Энхцэцэгийн илтгэлд бяцхан тайлбар нэмэрлэе. Учир нь илтгэлд ашиглаж буй гадаад үг хэллэгийн торгон ялгааг ойлгож мэдрэх нь чухал юм. О. Энхцэцэг гадны цөмийн хаягдал гэдгийг тодруулж **“гадны гаралтай цөмийн хаягдлыг” (foreign-origin nuclear waste)** нутагтаа оруулахгүй гэж ярьсан байна.

Үнэндээ гарал үүсэл ярьвал Монголоос гаралтай буюу Монголд олборлосон уранаар үйлдвэрлэж, бусад оронд нийлүүлсэн, гадны АЦС-д шатааж ашиглагдсан цөмийн түлшний хаягдалд түүний үг хамаарахгүй аж. **Ураныг нь Монголд олборлож, түлшийг Монголоос нийлүүлсэн нөхцөлд гарсан хаягдал нь “Монгол гаралтай түлшний хаягдал” (Mongolia-origin) болох аж. Тэгэхээр Монголын ураны түлшийг гадны орныхон “зээлдэж” ашиглачихаад, хаягдлыг нь буцаагаад явуулах боломжтой болж таарч байна.**


Чухамдаа, өнгөрсөн 6 сард Ц. Элбэгдоржтой уулзахдаа АНУ-ын ерөнхийлөгч Обамагийн сайшаасан Mongolian Nuclear Initiative (**Монголын Цөмийн Санаачлага**) төслийн (16) хүрээнд хэрэгжүүлэхээр бэлтгэж буй Comprehensive Fuel Services (**Цөмийн түлшний иж бүрэн үйлчилгээ**) гэдэг цөмийн түлш зээлдүүлэх үйлчилгээг Монголчууд хэрэгжүүлэхээс бүрмөсөн татгалзсан нь бодитоор харагдахгүй байна. Монгол улс уран олборлох, АЦС барих хэвээр цагт энэ төлөвлөгөө хэрэгжих нь бас үнэн байх болно.

Цөмийн хаягдлын асуудлыг Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл (ҮАБЗ)-ийн зөвшөөрөлгүйгээр хэлэлцэхийг хориглосон Ерөнхийлөгчийн зарлиг ч (17) саад болох биш харин тус асуудлыг хэлэлцэх цөөн хэдэн хүний монополь эрхийг баталгаажуулсан алхам бололтой. **Учир нь цөмийн түлшний банк байгуулах хөтөлбөрийн гол дэмжигчид нь ҮАБЗ-ийн нэр бүхий гишүүд өөрсдөө билээ.**

Uranium Monthly Price - US Dollars per Pound

Range 6m 1y 5y 10y 15y 20y 25y 30y

Sep 2006 - Sep 2011: -0.460 (-0.88 %)



<http://www.indexmundi.com/commodities/?commodity=uranium&months=60>

Ямартаа ч дэлхийн зах зээл дээр ураны үнэ сүүлийн жилүүдэд унасаар байхад уранаа яаравчлан олборлож, экспортлохоор зүтгэх, бусад орнууд цөмийн эрчим хүчнээс ээлж дараалан татгалзаж байхад АЦС барихаар шавдуулах, Чернобыль, Фукушимагийн ослын гашуун туршлага байсаар атал цөмийн энергийг хутга, онгоцтой зүйрлэн байж аюулгүй хэмээн “тархи угаах”, цөмийн хаягдлын талаар нууцаар гэрээ хэлэлцээр хийсэн паян нь дэлхийгээр нэг тарчихаад байхад “шар сонингууд бичиж байгаа юм” хэмээн хэв нэг худал ярьж, бүхэл бүтэн таван сар гаруйн туршид ард түмнээсээ ноцтой мэдээллийг нуун дарагдуулахыг санаархаж байсан зэргээс үзэхэд улс төрчдөд итгэж огт боломгүй байна.

Давтан хэлэхэд, уран олборлох, хөрвүүлэх, түлш үйлдвэрлэх, АЦС ажиллуулах цөмийн циклийн алхам бүрт хорт хаягдал ялгардаг. Тэр хорыг ашиглах, хадгалах аргагүй, зөвхөн булшлах болно. Харин гадна, дотны алин ч бай цөмийн хаягдал булшилвал Монголын 2.7 сая хүн ам дор хаяж 240 мянган жилийн туршид цацраг идэвхийн өндөр эрсдэлтэй орчинд амьдрахаас өөр

аргагүй. Бидний үйл лайг бид өөрсдөө үүрээд зогсохгүй, гэм буруугүй ирээдүй үеийнхэн маань эдлэх болно.

Монгол улс уран олборлож, АЦС барьж, цөмийн түлш боловсруулах төлөвлөгөөгөө бүрэн орхиогүй цагт, Монгол улс цөмийн түлшний иж бүрэн үйлчилгээ үзүүлэх (цөмийн түлш зээлдүүлэх) төлөвлөгөө хэвээр байгаа цагт, Монгол улсын хуулинд “дотоодын” ба “гадны цөмийн хаягдал” гэдэг тодорхой заагласан тайлбар үгүй цагт, бусад улс орнууд цөмийн хорт хаягдлын асуудлаа шийдээгүй цагт, Монгол төрийн тэргүүнд эх орноо наймаалахаас ч буцахгүй увайгүй улс төрчид байгаа цагт, сонгуулийн өмнө “хошгируулан” мэхлэх тактик ашигладаг нь хэвээр цагт та бид сонор сэрэмжээ алдаж хэрхэвч болохгүй.

Монгол улсад уран олборлох, АЦС байгуулах, цөмийн хорт хаягдал булшлахын эсрэг тууштай зогсоё!

Амарлин (amarlin06@gmail.com)

<http://golomt.org>

Ашигласан эх сурвалж:

- (1) Төрийн өмчит компани байгуулах тухай Засгийн газрын тогтоол. Дугаар 45. 2009 оны сарын 11.
<http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=44115>
- (2) МонАтом ХХК. Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн Энергийн газрын цахим хуудас.
http://nea.gov.mn/index.php?option=com_content&view=section&layout=blog&id=3&Itemid=44&limitstart=9&el_mcal_month=3&el_mcal_year=2062

- (3) Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай Засгийн газрын тогтоол. Дугаар 64. 2008 оны 12 сарын 24.
<http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=41695>
- (4) МонАтом компаний тухай. “МонАтом” ХХК цахим хуудас. Шинэчилсэн 2008 оны 8 сарын 9.
http://monatom.mn/index.php?option=com_content&view=article&id=70&Itemid=27&lang=mn
- (5) МонАтом Жапан компаний цахим хуудас. Япон хэл дээр.
<http://monatom-j.jp>.
- (6) Судлаач Д. Ганхуяг. Алтнаас үнэтэй шороо. 2011 оны 3 сарын 9. Зохиогчийн хувийн блог.
<http://gankhuyag.wordpress.com/2011/03/09/hkldwyg/>
- (7) Г. Отгонжаргал. Нэг км замын үнээр 93 км төмөр зам заржээ. 2010 оны 6 сарын 15.
http://www.postnews.mn/index.php?cp=news&task=view&news_id=8182
- (8) Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугар 93 км замыг 440 сая төгрөгөөр зарсан нь үнэн үү. 2009 оны 7 сарын 10.
<http://news.gogo.mn/r/56406>
- (9) Мардайн төмөр замыг УИХ-ын зөвшөөрөлгүй худалджээ . 2009 оны 7 сарын 9. <http://www.vip76.mn/altangerelpg/xevleliin-toim/7256-mardain-tomor-zamyg-uix-yn-zovshoorolgui-xudaldjee.html?tmpl=component>
- (10) Tokaimura nuclear accident /Токаймура үйлдвэр дээрх цөмийн осол. Википедия, интернэтийн үнэгүй лавлах.
http://en.wikipedia.org/wiki/Tokaimura_nuclear_accident

- (11) Tokaimura Criticality Accident / Токаймура дахь цөмийн урвалаас үүдсэн осол. 2007 оны 7 сар. World Nuclear Association.
<http://www.world-nuclear.org/info/inf37.html>
- (12) Nuclear News: Japanese nuclear waste reprocessing plant 15 years late after 18th postponement/ Цөмийн энергийн тухай шинэ мэдээ: Японы цөмийн хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн нээлтийг 19 дахь удаагаа хойшлуулсны улмаас 15 жилээр хоцорчээ. 2010 оны 10 сарын 12. Greenpeace international. Asahi сониноос авав.
<http://www.greenpeace.org/international/en/news/Blogs/nuclear-reaction/nuclear-news-japanese-nuclear-waste-reprocess/blog/26627/>
- (13) Rokkasho Reprocessing Plant Update. Роккашогийн дахин боловсруулах үйлдвэрийн тухай шинэ мэдээ. Citizens' Nuclear Information center.
<http://cnic.jp/english/newsletter/nit140/nit140articles/rokkasho.html>
- (14) Rokkasho Reprocessing Plant / Роккашо дахь цөмийн түлш дахин боловсруулах үйлдвэр. Википедия, интернэтийн үнэгүй лавлах.
http://en.wikipedia.org/wiki/Rokkasho_Reprocessing_Plant
- (15) НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 66-р хуралдаан дээр Монгол улсын суурин төлөөлөгч элчин сайд О. Энхцэцэгийн хэлсэн үгнээс. 2011 оны 10 сарын 7. Нью Йорк.
http://www.reachingcriticalwill.org/political/1com/1com11/statements/7-Oct_Mongolia.pdf
- (16) Монгол Улс, Америкын Нэгдсэн Улсын хамтарсан мэдэгдэл. Ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийн цахим сайт. 2011 оны 6 сарын 20.
<http://www.president.mn/mongolian/node/1891>
- (17) Ерөнхийлөгчийн цөмийн хаягдлын эсрэг зарлиг (эх хувь). 2011 оны 9 сарын 14. Масс.мн мэдээллийн портал. <http://mass.mn/d/8903>